



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

### Баянзүрх дүүргийн 136 дугаар сургуулийн балансаас хөрөнгө шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу Баянзүрх дүүргийн 136 дугаар сургуулийн балансад бүртгэлтэй хавсралтад заасан нийт 6,309,386,7 /зургаан сая гурван зуун есөн мянга гурван зуун наян зургаан төгрөг далан мөнгө/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг Баянзүрх дүүргийн 210 дугаар цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн 136 дугаар сургууль /Н.Отгонсүрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Баянзүрх дүүргийн 210 дугаар цэцэрлэг /Г.Наранцэцэг/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн 136 дугаар сургууль /Н.Отгонсүрэн/, Баянзүрх дүүргийн 210 дугаар цэцэрлэг /Г.Наранцэцэг/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус даалгасугай.

ДАРГА Ч.ОДНАСАН



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2019 оны 03 дугаар сарын 25 -ны өдрийн  
А/66 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: БЗД-ийн 136 дугаар сургуулийн балансаас БЗД-ийн 210 дугаар цэцэрлэгийн балансад

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд авсан он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	1-р хоолны тогоо	2016.08.31	ш	1	1,568,326.7	1,568,326.7	365,942.9	1,202,383.8
2	2-р хоолны тогоо	2016.08.31	ш	1	1,975,500.0	1,975,500.0	460,950.0	1,514,550.0
3	Бэлтгэлийн ширээ	2016.08.31	ш	1	289,426.7	289,426.7	67,532.9	221,893.8
4	Цахилгаан пийшин	2016.08.31	ш	1	2,476,133.3	2,476,133.3	577,764.3	1,898,369.0
<b>Нийт үнэ</b>						<b>6,309,386.7</b>	<b>1,472,190.1</b>	<b>4,837,196.6</b>